



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 28 өдөр

Дугаар А/460

Номгон

“Бууцагаан суманд замын хашлага хийх” ажлыг
эрх шилжүүлэн гүйцэтгүүлэх тухай

Монгол улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 3 “а” дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

“Бууцагаан суманд замын хашлага хийх” 37,000,000 (Гучин долоон сая) төгрөгийн ажлыг тус сумын Засаг даргын тамгын газарт эрх шилжүүлж гүйцэтгүүлсүгэй.

Эрх шилжсэнтэй холбогдуулан худалдан авах ажиллагааг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу 08 дугаар сарын 01-ний дотор зохион байгуулж, явцын ажилд хяналт тавьж ажиллахыг Бууцагаан сумын Засаг дарга (Д.Лхагвадорж)-д үүрэг болгосугай.

Дээрх 37,000,000 (Гучин долоон сая) төгрөгийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-д зөвшөөрсүгэй.

“Бууцагаан суманд замын хашлага хийх” ажилд хяналт тавьж цаг хугацаанд нь чанартай гүйцэтгүүлж хүлээн авч ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

601210065